



# МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ



**OUTBOUND  
TRAVEL  
MART**

M O N G O L I A

**2019**

**ГАДААД АЯЛЛЫН ҮЗЭСГЭЛЭН**



**“OTM - OUTBOUND TRAVEL MART” ГАДААД АЯЛЛЫН ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ:** Монголын Аялал Жуулчлалын Холбоо (МАЖХ) нь 1992 онд Монголын аялал жуулчлалын салбарт ажиллагсад болон анхны аялал жуулчлалын хувийн компаниудын санаачлагаар үүсгэн байгуулагдсан.


МАЖХ нь гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, Монгол улсын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх үндсэн зорилго бүхий гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус ТББ бөгөөд БОАЖЯамны зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэдэг, тогтвортой үйл ажиллагаатай, хамгийн олон гишүүнтэй /200/, Монголын аялал жуулчлалын салбарын хамгийн том, мэргэжлийн холбоо билээ.

**ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТУХАЙ:** Үзэсгэлэн нь гадаад улсуруу аялах сонирхолтой хэн бүхэнд мэдээлэл цуглуулах, оновчтой гарцаа олоход нэн чухал үзэсгэлэн болно.

Тус үзэсгэлэн нь МАЖХ-ны гишүүн байгууллагуудын санаачлагаар анх удаа 2019 оны 10-р сарын 18, 19-ний өдрүүдэд зохиогдох гэж байна. үзэсгэлэнгийн цар хүрээ, OUTBOUND ба дэлхийн улс орнуудад Монгол аялагчдыг аялуулдаг мэргэжлийн тур операторууд болон аялагчдад шаардлагатай үйлчилгээ үзүүлэгч байгууллага /тур оператор, даатгал, тийз захиалгын касс, банк, нислэгийн авиа компани, визний мэдүүлэх зөвөлгөө гэх мэт/-ууд нэгдсэн зохион байгуулалттай оролцох юм.

**БОЛОМЖ:** Гадны орнууд руу аялал зохион байгуулдаг мэргэжлийн, эрх бүхий тур оператор, үйлчилгээний байгууллагууд ирэх учир туршлага солилцох, бизнесийн шинэ түнштэй болох, аяллын бүтээгдэхүүнүүдтэй танилцах, худалдан авах, баталгаажуулах, аялал жуулчлалын бизнесийн эрх зүй, олон улсын стандарт, шинэ чиг хандлагын талаар гадаад дотоодын судлаачдын лекцэнд хамрагдах зэрэг боломжоор хангагдана.

### **БАЙРШИЛ: Сүхбаатар дүүрэг, 2-р хороо “ТУСГААР ТОГТНОЛЫН ОРДОН”**



**БҮРТГЭЛИЙН НӨХЦӨЛ:** Бүртгэл 2019 оны 10-р сарын 01-ээс эхэлж 10 сарын 11-ний өдөр 18:00-цагт дуусна. Бүртгэлийг Аялал Жуулчлалын Холбооны байранд хүргэж өгөх эсвэл [/info@travelmongolia.org/](mailto:info@travelmongolia.org) и-мэйл хаягаар бүртгэлээ илгээнэ. Таны бүртгүүлсэн и-мэйл хаягт төлбөрийн нэхэмжлэлийг илгээж, албан ёсны гэрээг МАЖХ-ны байранд хийгдсэнээр таны захиалга баталгаажна.

Дэлгэрэнгүй мэдээллийг **7000-7820** дугаарын утсаар лавлах

### **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ**

- Тур агент
- Тур оператор /аутбаунд ангилал/
- Агаарын тээвэр, Төмөр зам, Авто тээвэр
- Даатгалын байгууллага
- Банк санхүүгийн байгууллага
- Визний үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд

### **УУЛЗАЛТ, ХУРАЛ:**

Монголын аялал жуулчлалын салбарын тур компани, тээврийн үйлчилгээний компани зэрэг томоохон аж ахуйн нэгжүүдтэй гэрээ хэлэлцээр байгуулах, шинээр түншлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, туршлага солилцох боломжоор хангагдана.



### **Хурал уулзалтын үндсэн чиглэлүүд:**

- Нислэгийн компаниуд, Тур оператор болон МАЖХ-ны төлөөлөл /аутбаунд тур операторуудад нислэгийн тийз-нд хөнгөлөлт, урамшуулал олгодог болгох, үнийн тогтвортой байдлыг баримтлаж ажиллах/
- Хил хамгаалах ерөнхий газар /дотоод хяналтын газар/, МАЖХ-ны төлөөлөл /мэргэжлийн тур опертор байгууллагууд хил, боомтоор нэвтрэх асуудлаар гарц, гаргалгаа бий болгох боломж/
- Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, МАЖХ-ны төлөөлөл /хэрэглэгчийн эрх ашиг, байгууллагуудын шудрага өрсөлдөөнийг хангах боломж/

### **УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА:**

- Дэлхийгээр аялагч олны танил илтгэгч нараар яриа хийлгэх /илтгэгч нь өөрийн туршлагаас үндэслэн аялагчдад өгөх зөвлөгөө, санал, санаачилга сэдэвт цуврал лекц/

## **ХӨТӨЛБӨР:**

### **10-р сарын 18-ний өдөр /баасан гариг/**

09:30 Үзэсгэлэн эхэлнэ

11:10 Хүндэт зочдыг угтан авах

11:30 Үзэсгэлэнгийн албан ёсны нээлт /хөтлөгч/

11:30-11:40 Урлагийн тоглолт

11:40 МАЖХ-ны ерөнхийлөгч Д.Гантөмөр үг хэлнэ

11:45 МУ-ын Гадаад харилцааны яам, Консулын газрын дарга Л.Мөнхтүшиг үг хэлнэ

Бусад үг хэлэх хүмүүсийг нэмэх .....

12:00 Үзэсгэлэнгийн үйл ажиллагаатай хүндэт зочид танилцана

13:00 Оролцогч байгууллагуудын гадаад аяллын танилцуулга

14:30 Хурал уулзалт

- “Аутбаунд зөвлөлийн нээлттэй уулзалт”

- “Байгууллагуудын шударга өрсөлдөөн” сэдэвт уулзалт /Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн/

- Нислэгийн авиа компани Аутбаунд Тур оператор байгууллагуудын бизнес уулзалт

15:00 “Аяллын сэтгэл ханамж” сонирхолтой яриа, лекц “Аяллын тойрог” төслийн Продюсер, Аялагч Ц.Ган-Өлзий

16:00 Азтан шалгаруулна. /Оролцогч байгууллагын нэрэмжит Гадаадад аялах эрхийн бичиг/

### **10-р сарын 19-ний өдөр /бямба гариг/**

10:00 Үзэсгэлэн эхэлнэ

11:00 Оролцогч байгууллагуудын гадаад аяллын танилцуулга

13:00 Яриа лекц “Дэлхийгээр аялагч групп”

14:00 оролцогч байгууллагын гадаад аяллын танилцуулга

15:00 Азтан шалгаруулах /Оролцогч байгууллагын нэрэмжит Гадаадад аялах эрхийн бичиг/

17:00 Үзэсгэлэнгийн үйл ажиллагаа хаалт

2020 оны Удирдамж 8 сард мэдээлэл оруулна.